



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

А.Эрдэнэчимхэ-т
Гүйцэтгэх хэлтэс
Төвт, амжилдад,
2024/05.

2024 оны 10 дугаар сарын 22

Дугаар А/179

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн
сарын хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

Хоёр.Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар /Б.Алтанцэцэг/-т, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт тус тус даалгасугай.

Гурав.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн "Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/154 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Тав.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ДҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1. Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.10.23 № 01/2192
танай _____ -ны № _____ -Т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ


Төсвийн хуваарь
хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн "Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/179 дүгээр тушаалыг хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 10, 11, 12 дугаар сарын төсвийн хуваарьт аймаг, дүүргийн хэмнэгдэж байгаа зардлын төсвөөс шаардлагатай аймаг, дүүргийн зардлын төсөв хооронд зохицуулалт хийсэн болно.

Иймд батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан зориулалтын дагуу зарцуулж, төсвийн сахилга батыг хангаж ажиллахыг мэдэгдье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ

